



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 02

Эрдэнэбулган сум

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн
хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулах тухай

Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын 2 дугаар 7 хоногийн мэдээгээр аймгийн хэмжээнд амбулаториор үйлчлүүлэгчдийн 7,6 хувь нь томуу төст өвчнөөр оношилогдсон. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн амбулаторийн үзлэгт ТТӨ 9,1 хувийг эзэлж байна. Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн дуудлагын 17,4 хувийг ТТӨ-ний шалтгаант дуудлага эзэлж, цаашид томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэх хандлагатай байна.

ТТӨ-өөр өвчлөгчдийн 62,4 хувь нь 4 хүртлэх нас, 28,8 хувь нь 5-15 насны хүүхэд байна.

Иймд томуу, томуу төст өвчний үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүндрэлээс сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хүүхэд гэртээ хүндрэхээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой хүндрэл, эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь албан даалгаврыг хүргүүлж байна. Үүнд:

НЭГ. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ:

1. Хүүхдийн тасаг, яаралтай, түргэн тусламжийн эмч нар болон бусад тасгийн эмч нарт “2021-2022 оны томуугийн улиралд баримтлах эмнэл зүйн удирдамж”-ийн сургалтыг зохион байгуулах
2. Тамифлю эмийн нөөцийг бүрдүүлэх
3. Эмнэлгийн орны ачааллыг зохицуулах, орны тоог нэмэгдүүлэх, нэмэлт хүүхдийн тасаг дэлгэх төлөвлөгөөний бэлэн байдлыг хангах
4. Хүүхдийн тасгийн эрүүл ахуй, халдвар хамгаалалд үнэлгээ хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
5. Хүүхдийн амбулатори болон түргэн тусламжаар үзүүлээд гэрт нь буцаасан, үлдээсэн хүүхэд, жирэмсэн эхийн мэдээллийг харъяа өрхүүдэд нь өглөө бүр мэдээлж байх
6. Хүүхдийн амбулаторийн үзлэгт нэмэлт пост гаргаж ажиллуулах
7. Сумын эрүүл мэндийн төвүүдээс өгсөн алсын дуудлагыг түргэн шуурхай шийдвэрлэх

8. Өвчний учир үзүүлсэн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт хэзээ эргэж үзүүлэх, хэзээ ЯАРАЛТАЙ эргэж үзүүлэхийг сайн зөвлөж, гэрт хүндрэхээс сэргийлэх

ХОЁР. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД:


1. Бүх их эмч, багийн эмч, бусад бага эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “2021-2022 оны томуугийн улиралд баримтлах эмнэл зүйн удирдамж”-ийн сургалтыг зохион байгуулах
2. Тамифлю эмийн нөөцийг бүрдүүлэх
3. Өвчний учир үзүүлсэн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт хэзээ эргэж үзүүлэх, хэзээ ЯАРАЛТАЙ эргэж үзүүлэхийг сайн зөвлөж, ХӨЦМ-ийн дагуу давтан үзлэгийг тогтмол хийж, гэрт хүндрэхээс сэргийлэх
4. Эмнэлгийн орны ачааллыг зохицуулах, орны тоог нэмэгдүүлэх, нэмэлт хүүхдийн өрөө дэлгэх төлөвлөгөөний бэлэн байдлыг хангах
5. Эрүүл мэндийн төвийн эрүүл ахуй, халдвар хамгаалалд үнэлгээ хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
6. Амбулаториор үзүүлээд гэрт нь буцаасан болон түргэн тусламжаар үзүүлээд гэрт нь үлдээсэн ТТӨ-тэй хүүхэд, жирэмсэн эхийн мэдээллийг харъяа багийн эмч, гудамж хороолол хариуцсан бага эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд мэдээлж, гэрээр эргэлт хяналт хийлгүүлэх
7. Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний өрөөний тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах, нөөцийг бүрдүүлэх
8. Харъяа нутаг дэвсгэрийн сургууль, цэцэрлэгийн хүүхдийн ирцийн байдалд тандалт хийх, сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуйн дэглэмийн хэрэгжилт, ТТӨ-ний үед сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэнд дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжөөр хангах, шаардлага тавих
9. Сургуулийн үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолонд аминдэм, эрдэс бодисоор баялаг, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүнийг сонгохыг сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөх
10. Иргэдэд “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх” мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах
11. Өвчлөлийн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын цагийг уртасгах, амралтын өдрүүдэд ажиллах жижүүр эмч нарын хуваарь гаргаж, ажиллуулах

ГУРАВ. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД:

1. Бүх их эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “2021-2022 оны томуугийн улиралд баримтлах эмнэл зүйн шинэчилсэн удирдамж”-ийн сургалтыг зохион байгуулах
2. Тамифлю эмийн нөөцийг бүрдүүлэх
3. Өвчний учир үзүүлсэн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт хэзээ эргэж үзүүлэх, хэзээ ЯАРАЛТАЙ эргэж үзүүлэхийг сайн зөвлөж, ХӨЦМ-ийн дагуу давтан үзлэгийг тогтмол хийж, гэрт хүндрэхээс сэргийлэх

4. Хүүхдийн амбулаториор үзүүлээд гэрт нь буцаасан болон түргэн тусламжаар үзүүлээд гэрт нь үлдээсэн ТТӨ-тэй хүүхэд, жирэмсэн эхийн мэдээллийг Нэгдсэн эмнэлгээс өглөө бүр авч, гэрийн эргэлт, хяналтыг хийх
5. Харьяа сургууль, цэцэрлэгийн хүүхдийн ирцийн байдалд тандалт хийх, сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуйн дэглэмийн хэрэгжилт, ТТӨ-ний үед сургууль, цэцэрлэгт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэнд дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжөөр хангах, шаардлага тавих
6. Сургуулийн үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолонд аминдэм, эрдэс бодисоор баялаг, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүнийг сонгохыг харъяа сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөх
7. Иргэдэд “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх” мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах
8. Өвчлөлийн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын цагийг уртасгах, амралтын өдрүүдэд ажиллах жижүүр эмч нарын хуваарь гаргаж, ажиллуулах

ДАРГА



Р.ГАНДИЙМАА